



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 18 өдөр

Дугаар А/500

Номгон

Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Ганьсу мужийн албан төлөөлөгчдийг Баянхонгор аймагт ажиллах үеэр хөрөнгө зарцуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.9, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.5, аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4 дүгээр хэсгийн 4.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Ганьсу мужийн Улс төрийн зөвлөлдөх зөвлөлийн дэд дарга Юн Жиамин тэргүүтэй төлөөлөгчдийн Баянхонгор аймагт хүрэлцэн ирж албан уулзалтад оролцох болон Баянхонгор аймгийн Хөгжимт драмын театрын уран бүтээлчид, Ганьсу мужийн үндэсний дуу бүжгийн чуулганы уран бүтээлчдийн хамтарсан урлагийн тоглолтыг зохион байгуулах ажлыг үр дүнтэй зохион байгуулсугай.

2.Албан төлөөлөгчдийг Баянхонгор аймагт угтан авах, үдэх, хүлээн авч уулзах, гарын бэлэг гардуулах болон аймагт туршлага солилцох хугацааны өдрийн хоолны зардлуудад 3,652,200 (Гурван сая зургаан зуун тавин хоёр мянга хоёр зуун төгрөг)-ийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д. Энхжаргал)-д зөвшөөрсүгэй.

3.Баянхонгор аймаг, Ганьсу муж хоорондын боловсрол, соёл урлагийн салбарын хамтын ажиллагааны эрчийг хадгалж, харилцан ашигтай байх зарчмыг баримтлан ажиллахыг Төрийн Захиргааны Удирдлагын Хэлтсийн дарга (П.Отгонбаяр), Баянхонгор сумын Засаг дарга бөгөөд Хотын Захирагч (Г.Энхбаяр) нарт даалгасугай.

4.Албан төлөөлөгчдийн уулзалтын протокол, хамтарсан урлагийн тоглолтын тайлан мэдээллийг хүлээн авч, үр дүнг тооцож, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Орлогч (Б.Батсуурь)-д даалгасугай.

ДАРГА

Д.МӨНХСАЙХАН

642311291